



ИННО ХИМИ ЛАБ ХХК

7 хоногийн мэдээлэл

МЭДЭЭЛЛИЙН НЭР:

**Randox Toxicology, Evidence+ бүрэн
автомат шинжилгээний багажийн
танилцуулга**

*(Энэхүү орчуулга нь албан бус орчуулга
болно)*

Утас: 77051414

И-мэйл: info@innocchem.mn

Вэбсайт: www.medimpex.mn

Фэйсбүүк:

Инно лаборатори

Agilent Demo Center

Evidence+

Илүү хурдан, Нарийвчлалтай үр дүн гаргана

Та бүхэнд энэ долоо хоногийн мэнд хүргэхийн ялдамд Инно Хими Лаб компанийн хамт олноос долоо хоног тутмын орчуулгын мэдээллээ (Хавсралтаар) хүргэж байна. Энэ удаа бид дэвшилтэт технологи бүхий лабораторийн шинжилгээний багаж үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч Randox компанийн хор судлал, шүүх эмнэлгийн шинжилгээний бүрэн автомат **Evidence+** багажийн танилцуулгыг Монгол хэлнээ орчуулан хүргэж байна.

Тус багажийн талаар дэлгэрэнгүй танилцахыг хүсвэл та бүхэн линкээр орж англи хэл дээр мэдээллийг уншиж болно.

- ✓ Мэдээллийн эх сурвалж: (<https://www.randox.com/evidence-plus/>)

✚ Мөн Randox компани овор хэмжээ, хүчин чадлын хувьд жижигхэн, мансууруулах бодисын шинжилгээний **Evidence MultiSTAT** загварыг үйлдвэрлэдэг бөгөөд нэгэн зэрэг, нэг дээжид 29 хүртэл тооны түгээмэл тохиолддог, жороор олгодог болон синтетик сэтгэцэд нөлөөтэй эмүүд, мансууруулах бодисын шинжилгээг тодорхойлох боломжтой.

Энэхүү шинжилгээ нь олон төрлийн матриц буюу дээжид шинжилгээ хийх боломжтой бөгөөд патентжуулсан иммунологийн иж бүрэн багцыг хэдхэн минутын дотор илрүүлэх мансууруулах бодис илрүүлэлтийн хэв маягийг бүрэн өөрчилж чадсан гэж үздэг байна.

- ✓ Мэдээллийн эх сурвалж: (<https://randoxtoxicology.com/analysers/evidence-multistat/>)

Тус багаж нь зах зээлд байгаа шинжилгээний багажуудаас ашиглахад хамгийн хялбар багаж бөгөөд 15.6 инчийн ухаалаг дэлгэцийг ашиглан программыг ажиллуулах энгийн шийдэлтэй, цагт 6 хүртэл дээжийг шинжлэх чадамжтай. **MultiSTAT** багажийг лабораторийн бус нөхцөлд, заавал лабораторийн бус хүн ч ажиллуулах боломжтой. Дээжийг багажид оруулахаас шинжилгээний үр дүнг гаргах хүртэл ердөө 3 үйлдлийг хийх боломжтой бөгөөд шинжилгээний хариуг 30 минутаас бага хугацаанд гаргаж байгаа нь өндөр нарийвчлалтай, мансууруулах төрлийн шинжилгээнд найдвартай сонголт болж чадах юм.

Evidence MultiSTAT багажийн танилцуулга видео бичлэгийг доорхи линкүүдээр орж танилцаарай:

- ✓ Багажийн талаар нэмэлт мэдээлэл авах эх сурвалж:
 - **Evidence MultiSTAT:** Багажийг хууль хүчний байгууллагууд хэрхэн хэрэглэж байгаа талаар: <https://www.youtube.com/watch?v=i0t2fg6LwGs>;
 - Багажийн танилцуулга: [Evidence MultiSTAT Demonstration - YouTube](#)

Evidence+ багажийн танилцуулгын агуулга:

Evidence+

Давуу тал

Матриц, дээжүүдийн төрөл

Evidence+ -ийн ажиллагаа

Системийн танилцуулга

Шинжилгээний төрөл

Программ хангамж

Үр дүн

Техникийн дэмжлэг

Техникийн тодорхойлолт

Randox Toxicology- Зөвхөн хор судлалын чиглэлээр ашиглана

Randox Toxicology нь шинэлэг Biochip Array буюу матрицын биочип технологийг ашиглан 500 гаруй эм, эмийн метаболитыг илрүүлэх чадвартай, мансууруулах бодисын шинжилгээний шийдлүүдээрээ дэлхийд тэргүүлэгч юм.



Evidence+

Бүрэн автомат, Evidence+ шинжилгээний багаж нь дэлхий хэмжээнд лабораториудад үнэхээр хувьсгалыг хийж чадсан. Бүрэн автомат, багц дархлааны шинжилгээг хийх, чанар, стандарт, бүтээмж, найдвартай байдлын өндөр стандартыг хангасан энэхүү багаж нь нэг дээжээс эм болон эмийн метаболит бодисуудыг нэгэн зэрэг илрүүлдэг.

Evidence+ багаж нь бүтээмж өндөртэй, хямд өртөгтэй шинжилгээ хийх боломжийг олгож байгаа ч гэсэн, өндөр хүчин чадалтай том лабораториудад үнэн зөв, найдвартай үр дүнг гаргаж өгнө.

Biochip Array Technology нь хоорондоо холбоотой шинжилгээний жижигхэн хавтгай дээр нэгэн зэрэг олон аналит нэгдлүүдийг илрүүлэх дархлааны шинжилгээний платформ юм. Энэ технологи нь урвалж, калибровк, хяналтын ганцхан багцыг ашиглан нэг биочип дээр 44 хүртэл холбоотой хавтгайнуудыг нэгтгэсэн байдлаар ажилладаг. Biochip Array-д химийн урвалын үед гэрэл үүсгэх дархлааны урвалыг ашигладаг. Биочип дээр байрлах салангид шинжилгээний хавтгай бүрээс үүсэх гэрлийн дохиог дижитал дүрслэлийн технологийг ашиглан нэгэн зэрэг илрүүлж калибровкийн муруйтай харьцуулна.

Түлхүүр үгс:

- Тус тусдаа байрлах, шинжилгээний бүс



- **Чанарын хяналтын цэг** 7x7 Биочипийн гадаргуу

Биочип бүр дээр байрласан аналит бодис тус бүрийг илрүүлэх 44 салангид шинжилгээний бүс

Давуу талууд



Олон дээжийг шинжлэх чадамжтай

5280 хүртэл шинжилгээний үр дүнг гаргах чадамжтай, нэг дээжид 44 шинжилгээ хийх Evidence+ багаж нь хурдан хугацаанд өндөр нарийвчлалтай шинжилгээнүүдийг хийхээр зохион бүтээгдсэн багаж юм.



Нарийвчлал өндөртэй шинжилгээ

Илүү нарийвчилсан шинжилгээнд бага дээж, цөөхөн дагалдах хэрэглэлийг ашиглах замаар санхүүгийн хувьд илүү үнэ цэнтэй байх Матрицан Биочип Технологи (Biochip Array Technology) нь ихэвчлэн стандарт өөрчлөлтийн хувьд <10% байх, олон шинжилгээг зэрэг хийх чадамжтай учраас шинжилгээнүүдийн хооронд гарах зөрүүг хамгийн бага байлгаж чаддаг, батлагдсан өндөр стандарт бүхий шинжилгээ хийдэг.



Ажлын даалгаврыг хадгалах

Байнга ашигладаг шинжилгээний жагсаалтыг ажилтан систем рүү дахин дуудах боломжийг олгосноор өөр дээжид шинжилгээг хийхдээ хэдхэн товчлуурыг дарж, ингэснээр 45 минутаас бага хугацаанд эхний үр дүнг гаргаж авахаар тохиргоог хийсэн.



Чанарын хяналтын харах хугацааг уртасгах

Чанарын хяналтын харах хугацааг уртасгаж өгснөөр систем дээр 180 өдөр хүртэл үр дүнг харуулах бөгөөд ингэснээр ажилтан калбировк болон хяналтын үр дүнгийн мэдээллүүдэд дүгнэлт гаргах боломжийг олгоно.



Email - ээр анхааруулгыг илгээх

Мессеж болон дохиоллыг хэрэглэгч нар руу явуулах тохиргоог системд суулгаж өгсөн тул өдөр бүрийн лабораторийн ажлыг илүү хурдавчилж, бүтээмжийг нэмэгдүүлж, мөн системээс хол байх хугацааг уртасгаж өгнө.



Зураасан код бүхий урвалжууд

Урвалжуудыг бар кодоор тэмдэглэж, сигналыг ашиглан тооцооллыг хийснээр буруу урвалжийг ашиглах, хүнээс хамааралтай алдаа гаралтыг багасган, хамгийн үнэн зөв үр дүнг бүхий шийдэл, хариуг гаргана.

Матриц, дээжийн төрлүүд

Цус



- Энгийн дээж бэлтгэл
- Бүхэл цусны дээжид зориулсан китийг ашиглах учраас үр дүнг хэвийн гаргах баталгаа өгнө
- Дахин калибровк хийх, эсвэл өөр калибровк хийхээс зайлсхийж, илрүүлж болох хязгаарыг сонгох боломжтой.

Үхлийн дараах цус



- Маш бага хэмжээний дээж шаардана
- Хатуу фазын хандлалтын багана болон уусгагч шаардлагагүй
- Энгийн дээж бэлтгэлтэй

Шээс



- Дээж бэлтгэл шаардлагагүй
- Худал үр дүн гаралтыг бууруулж баталгаажсан

Амны хөндийн шингэн



- Амны хөндийн шингэн цуглуулах олон хэрэгслэлүүдтэй ажиллахад тохирно
- Амны хөндийн шингэний дээжид зориулсан китийг ашиглах учраас үр дүнг хэвийн гаргах баталгаа өгнө.

Эд*



- Хар тамхины шинжилгээний хөтөлбөрт шаардлагагүй
- Нэг ангилалд хамаарах хар тамхины бодисуудыг салгахад гарах алдаатай үр дүн цөөхөн гаргана
- Биочип нь эдийн бэлдэц буюу гомогенат гарган авах процессын оновчтой байдал болон нарийвчлалыг нэмэгдүүлдэг.

Meconium*



- Жирэмслэлтийн үеийн хар тамхийг илрүүлэх хамгийн сайн аргачлал хэмээн тооцогддог
- Нэг ангилалд хамаарах хар тамхины бодисуудыг салгахад гарах алдаатай үр дүн цөөхөн гаргана
- Нэг meconium-ийн дээжээс нэгэн зэрэг олон төрлийн хар тамхи, тэдгээрийн мета болитуудын илрүүлэлтийг хийх боломжтой.

Үс*



- Дээж цуглуулалт харьцангуй энгийн, нээлттэй биш
- Удаан хугацаанд хэрэглээний хяналтыг хийж болно
- Өнгөрсөн хэдэн сарын хугацаанд хар тамхи хэрэглэж байсан түүхийг тодорхойлж чадна.

Шиллэг бие (Vitreous Humor)*




- Энэ төрлийн матрицтай тодорхой төрлийн эмүүдийн тогтвортой байдал нэмэгдэнэ
- Бусад матриц ашиглах боломжгүй үед шинжилгээг хийх боломжтой
- Дээжийн хэмжээ хязгаарлагдмал үед олон шинжилгээг нэгэн зэрэг хийх давуу талтай.

*Шинжилгээний цэсийг цус, шээс болон амны хөндийн шингэний дээжид зориулж баталгаажуулсан байдаг бөгөөд бусад матрицуудад ч гэсэн хэрэглэх боломжтой.

Evidence+ -ийн ажиллагаа

Evidence+-ийн шинжилгээний үе шат 1-р алхам, 2-р алхам Биочипийн нүх рүү шинжилгээний шингэрүүлэгч, дээж, конъюгетийг хийнэ, 3-р алхам Биочипийг инкубацид байлгана, 4-р алхам Биочипийг угаана, 5-р алхам Сигналын урвалжуудыг Биочипийн нүх рүү хийнэ, 6-р алхам Биочипийг дүрслэлийн хайрцаг руу оруулахад химийн урвалын дүнд үүсэх гэрлийг хэмжинэ, 7-р алхам Шинжилгээний үр дүнг мэдээлнэ.



Evidence+ Системийн танилцуулга



1. Дээж тавих тавиур



2. Урвалжуудыг нийтэд нь байрлуулах хэс



3. Кассетуудыг цуглуулах хэсэг





4. Кассетыг байрлуулах багана



5. Хүйтэн урвалжуудыг зөөж тавих тавцан



6. Биологийн аюултай хаягдлыг цуглуулах хэсэг

Шинжилгээний цэс

Мансууруулах төрлийн эм Array
Ultra/DUID

Assays	
Amphetamine	Meprobamate
Barbiturates	Methadone
Benzodiazepines I (Oxazepam)	Methamphetamine
Benzodiazepines II (Lorazepam)	Opiate
Benzodiazepines III (Clonazepam)	Oxycodone I
Benzoylgonine (Cocaine Metabolite)	Oxycodone II
Buprenorphine	Phencyclidine (PCP)
Cannabinoids (THC)	Tramadol
Dextromethorphan	Tricyclic Antidepressants (TCA)
Fentanyl	Zolpidem
Generic Opioids	-

Шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх эмүүд
I

Assays	
AB-CHMINACA (Synthetic Cannabinoids)	Mescaline
AB-PINACA (Synthetic Cannabinoids)	Phenylpiperazines I
Bath Salts I (Mephedrone / Methcathinone)	Phenylpiperazines II
Bath Salts II (α-PVP / MDPV)	Salvinorin
Benzylpiperazines	UR-144/XLR-11 (Synthetic Cannabinoids)
JWH-018 (Synthetic Cannabinoids)	-

Шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх эмүүд
II

Assays	
Acetylfentanyl	Mitragynine
AH-792 I	MT-45
Buprenorphine	Naloxone
Carfentanil/Remifentanil	Ocfentanyl
Clonazepam	Sufentanil
Etizolam	U-47700
Furanylfentanyl	W-19

Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу оруулж болох шинжилгээний цэс

Өвчин намдаагчид

Assays	
6-MAM	O-desmethyiltramadol
Acetaminophen	Opiate
Buprenorphine / Norbuprenorphine	Oxycodone I
EDDP	Oxycodone II
Fentanyl	Phencyclidine (PCP)
Generic Opioids	Propoxyphene
Hydrocodone	Salicylate
Hydromorphone	Tapentadol
Ibuprofen	Tilidine / Nortilidine
Meperidine	Topiramate
Methadone	Tramadol
Naloxone	-

Жороор бичих эмүүд

Assays	
Baclofen	Olanzapine
Bumetanide	Oxcarbazepine
Carbamazepine	Paroxetine
Clonidine	Phenytoin
Clozapine	Pipradrol
Diphenhydramine	Quetiapine
Escitalopram	Rimonabant (STR141716A)
Fluoxetine	Ritalinic Acid
Fluvoxamine	Scopolamine
Haloperidol	Sertraline
Lamotrigine	Tadalafil
Levetiracetam	Theophylline
Loperamide	Trazodone
Methocarbamol	Tricyclic Antidepressants (TCA)
Methylphenidate	Tripelennamine
Mirtazapine	Valproic Acid
Modafinil	Venlafaxine / O-desmethylvenlafaxine
Naltrexone	-

Шинэ төрлийн сэтгэгцэд нөлөөлөх эмүүд

Assays	
α-PVP / MDPV (Bath Salts)	MDMD-CHMZCA (Synthetic Cannabinoids)
Acetylfentanyl	Mescaline
AB-CHMINACA (Synthetic Cannabinoids)	Methoxydiphenidine (2-MeO-Diphenidine, MXP)
AB-FUBINACA (Synthetic Cannabinoids)	Mephedrone / Methcathinone (Bath Salts)
AB-PINACA (Synthetic Cannabinoids)	Mitragynine
ADBICA (Synthetic Cannabinoids)	MN-18 / 5F-MN-24 (Synthetic Cannabinoids)
AH-7921	MT-45
APP-CHMINACA (Synthetic Cannabinoids)	NBOMe
APP-FUBINACA (Synthetic Cannabinoids)	Ocfentanyl
BB-22 (Synthetic Cannabinoids)	PB-22 (Synthetic Cannabinoids)
Benzylpiperazines	Phenylpiperazines I
Carfentanil/Remifentanil	Phenylpiperazines II
Cumyl-PINACA (Synthetic Cannabinoids)	Salvinorin
FUB-AMB (Synthetic Cannabinoids)	Sufentanil
Furanylfentanyl	UR-144/XLR-11 (Synthetic Cannabinoids)
JWH-018 (Synthetic Cannabinoids)	U-50488
JWH-250 / RCS-8 (Synthetic Cannabinoids)	U-47700
MAB-CHMINACA (Synthetic Cannabinoids)	URBs
MDMB-CHMICA (Synthetic Cannabinoids)	W-19

Тайвшруулах эм Sedative Hypnotics

Assays	
Barbiturates	Methaqualone
Benzodiazepines I (Oxazepam)	Methoxetamine
Benzodiazepines II (Lorazepam)	Norketamine
Benzodiazepines III (Clonazepam)	Phenobarbital
Chloral Hydrate Metabolite	Primidone
Etizolam	Propofol
Flunitrazepam	Zaleplon
Ketamine/Norketamine	Zolpidem
Meprobamate	Zopiclone

Сэргээгч, хүч оруулагч
бодисууд

Assays	
Amphetamine	Mazindol
Benzoylcegonine (Cocaine Metabolite)	MDMA
Diethylpropion	Methamphetamine
DMAA	Phenmetrazine / Fluorophenmetrazine
DOx Series	Tetrahydracannabinol (THC)
LSD	-

Бусад


Assays	
Atropine	Ethyl Glucuronide (EtG)
Benzhexol	Gabapentin
Bupropion	Methotrexate
Creatinine	Pregabalin
Doxylamine	Sildenafil (Viagra)
Dextromethorphan	-

Ухаалаг программ хангамж



Багажны үндсэн дэлгэц


The Evidence+ Багажийг ажиллуулахад түгээмэл хэрэглэдэг системийн заалтуудыг оператор ашиглахад хялбар болгосон программ хангамжийн шийдлийг хөгжүүлсэн



Хяналтын самбар бүхий дэлгэц


Хяналтын самбар бүхий дэлгэцийн тусламжтайгаар ажилтан богино хугацаанд, хялбархан шинжилгээ хийж буй модулиуд, дагалдах хэрэглэлүүд, урвалж бодисын мэдээллийг өнгөт тэмдэглэгээтэйгээр харж болно

Чанарын хяналт




Evidence+ болон Чанарын хяналтын программ хангамж нь шинжилгээний статистик мэдээллүүд болох дундаж утга, стандарт хазайлт, (SD), вариацийн коэффициент (CV), бүх анализуудын Levey-Jennings -ийн график зэргийг харуулна. Хяналтыг график байдлаар 180 хоног хүртэл харуулдаг бөгөөд өдөр бүр, эсвэл багцалж байгаад харах боломжтой.

Дээжийн мэдээллийг багаж дээр харах




Системийн программын тусламжтайгаар шинжилгээ хийгдэж буй үеийн багажийн ажиллах төлөв байдал, дээж бүрийн шинжилгээ дуусах хугацаа (хамгийн ойрын хугацаанд дуусах) зэргийг харах боломжтой.

Үр дүнгийн түүх



Сонирхож буй дээжийнхээ үр дүнг харж, хэвлэж, эсвэл мэдээллийг авч болно. Шинжилгээний хязгаараас хамаарч үр дүнг чанарын болон тоон утгаар гаргана.

Калибровкийн түүх



Калибровкийн түүхийг дэлгэц дээр харуулснаар шинжилгээний цар хүрээ, хэрэглэж буй урвалж бодисуудаас хамаарч операторын зүгээс тухайн аналит бодисын калибровкийн муруйн үзүүлэлтийг багажин дээр харж болно.

Үр дүнг гаргах

The screenshot displays several overlapping report windows from the Randox Toxicology software. The primary window, 'Drugs of Abuse Report', shows a detailed table of test results. It includes columns for 'Sample ID', 'Result', and 'Units'. The results are organized into sections for different substances. Other visible windows include 'Drugs of Abuse Summary Report', 'Drugs of Abuse Positive Values Report', and 'Calibration Summary', each providing a different level of detail and summary for the testing process. The interface uses a standard Windows-style layout with multiple panes and a clear hierarchy of information.

Оператор өнгөөр кодолсон үр дүнг харснаар эерэг, сөрөг, хамгийн суурь үзүүлэлтүүдийг хялбархан ялгах боломжтой. Хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн шинжилгээний үр дүнг гаргах, маягтын толгойг өөрчилж болох бөгөөд ингэснээр шинжилгээний үр дүнг илүү хэрэглэгчид нийцүүлэх, тухайн лабораторийг таниулж сурталчлах боломжийг олгодог. Үр дүнгийн тайлан нэгтгэлд шинжилгээний үр дүнг өнгөт форматад оруулсан гол мэдээллүүд болох калибровк, хяналт, дээжийн үр дүн гэсэн мэдээллүүдийг багтаасан.

Инженерийн үйлчилгээг авах

Дэлхий дахины Randox Хор судлалын үйлчилгээ нь хэрэглэгчдэд таатай байх баталгаатай багажийн засвар үйлчилгээгээр үргэлж дэмжиж ажилладаг. Багажийг ажиллуулахад үед та бүхэнд тулгарч болох ямар ч техникийн болон үйлчилгээний асуудлуудыг шийдвэрлэх боломжтой өндөр чадамжтай, мэргэжлийн баг тусламжийг газар дээр нь үзүүлэхэд бэлэн байна.

Дэлхий даяар байрлах оффис

Бид дэлхий даяар 100 гаруй мэргэжилтнүүдээрээ дамжуулан хэрэглэгчийн хүсэлтэд үр дүнтэй найдвартай хариу хүргүүлдэг. Бид хэрэглэгчидтэй шууд харилцаж ажиллах 25 олон улсын оффистой.

100+ Мэргэжилтнүүдтэй

Randox нь 100 гаруй инженер, техникийн ажилтнуудыг дэлхийн улс орнуудад байрлуулж, хэрэглэгчдийнхээ хүсэлтийг найдвартайгаар биелүүлэн ажиллаж байна.

350 Эрдэмтэд

Randox нь 350 эрдэмтдийг дэлхийн улс орнуудад байрлуулж, чанартай бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ санал болгож байна.

Дэлхий даяар байрлах дистрибьютерүүд

Бидэнд Randox-ийн Хор судлалын албан ёсны техникийн дистрибьютерүүд дэлхийн 100 гаруй оронд байдаг.

Борлуулалтын дараах үйлчилгээ

Таны санхүүгийн боломжид тохирсон, борлуулалтын дараах үйлчилгээний багцыг бид санал болгодог.

Evidence+ Техникийн тодорхойлолтууд

Багажны мэдээлэл	Бүрэн автомат Biochip Array шинжилгээний багаж (Ангилал 2, Лазерын бүтээгдэхүүн)
Хэмжээ	170 (өндөр) x 100 (гүн) x 200 (өргөн) cm
Жин	620kg (approx)
Биочипийн багтаамж	4 x Биочипийн кассет (40 Биочипийг зөөгч, 360 Биочип)
Биочипийн формат	1 x Биочипийг зөөгч (9 тусдаа -биочипийг багтаана)
Калибровкийн зарчим	9-н калибровкийн цэгтэй
Холболт	LIS / LIMS -тай холбогдож ажиллана
Орчин	16°C - 30°C
Инкубац хийх хугацаа	30 минут (Array specific)
Суурилуулалтын шаардлага	Evidence+ -ийг заавал 3 утаст цахилгааны эх үүсвэрт холбох шаардлагатай бөгөөд аюулгүйн газардуулагчтай байна
Шингэн хаягдал	Гадагш нь асгах, зайлуулах зорилгоор сугалж авна
LIS Холбоо	Хоёр чиглэлтэй: ASTM стандарт (RS232 Connection)
Хамгийн их бүтээмж	Нэг цагт 5.280 шинжилгээг хийнэ (Array specific)
Хэмжилтийн зарчим	Химийн урвалын үед үүсэх туяаг хэмжих (Chemiluminescence)
Ажиллуулах төлөв	Windows® суурилсан
Чанарын хяналт	Өргөн хүрээтэй чанарын хяналтын багцтай. Үүнд: Чанарын хяналтын бүтэн тайлан, Levey-Jennings-ийн график, олон дүрэмтэй Чанарын хяналтын сонголтууд
Урвалжийн багтаамж	16 урвалжийн үүртэй reagent wedges
Дээжийн бар код	Code 39, Codabar, Code 128, I 2 of 5, Code 93, UPC/EAN, Pharmacode
Дээжийн багтаамж	180
Дээжийн тيوبны тохиромж	12 мм эсвэл 16мм болон диаметр 100мм, 16мм тيوبны урт, 75мм диаметр, багадаа 500µl багтаамжтай. Дээжний аяганууд 15мм, диаметр 23 – 38мм, хамгийн багадаа 350µl-ийг тавиур дээрхи 16мм -ийн тيوب дээр тавина
Дээжийн дугуй тавиур	2 дээжний дугуй тавиур нэг дээрээ 90 хүртэлхи дээжний тيوبыг байрлуулах боломжтой
Дээжийн хэмжээ	Биочип бүрд 6 - 150µl (Array specific)
Системийн шингэн	Хүйтэн урвалжуудыг хадгалах, угаах, солиход зориулалтаар урвалжуудыг нийтэд нь хадгалах
Асаах / Унтраах хугацаа	Асаах унтраахад 8-10 минут
Эхний үр дүнг гаргах хугацаа	< 45 минутаас бага (Матриц бүрээс хамааралтай)

Хаяг

Radox Toxicology, 55 Diamond Road, Crumlin, Co Antrim, United Kingdom, BT29 4QY

T +44 (0) 28 9442 2413 E info@radoxtoxicology.com I radoxtoxicology.com

Radox Toxicology is a company registered within Northern Ireland with Company Number NI 069074. VAT Registered Number: GB 151 6827 08. Product availability may vary from country to country. Some products may be for Research Use Only. For more information on product application and availability, please contact your local Radox Representative.

Инно Хими Лаб ХХК – ийн танилцуулга:


Үйлчилгээний нэр төрөл:

- Хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээний лабораторийн шинжилгээ
- Химийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, урвалжийн худалдаа
- Химийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ
- Химич, химийн мэргэжилтний сургалт, зөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр төрөл:

- Тоног төхөөрөмж
- Лабораторийн тавилга
- Химийн урвалж, бодис, стандарт уусмал, оношлуур
- Шил сав, дагалдах хэрэгсэл

Хэрэглэгчидийнхээ цаг завьг хэмнэх, тасралтгүй ажиллагааг дэмжих үүднээс www.innochem.mn онлайн худалдааны сайтыг нэвтрүүлээд байна.



Инно лаборатори

- Химийн лабораторийн мэргэжилтнүүдэд өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах орчин бүрдүүлэх, чадамжийг сайжруулах
- Хүнсний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад лабораторийн шинжилгээг олон улсын стандартын дагуу нэвтрүүлж хувь нэмрээ оруулах

Шинжилгээний хүрээ:

- Пестицидийн үлдэгдлийн шинжилгээ
- Усанд болон тосонд уусдаг витаминь шинжилгээ
- Хүрээлэн буй орчны бохирдлын шинжилгээ